

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 6 сарын 19 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, 89 зүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигч Шинтани Такаёшигоос компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хавсралтад заасны дагуу зээл авахыг зөвшөөрсүгэй.
2. Зээлийн гэрээнд компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг компанийн ТУЗ-ийн дарга Ч.Чинзоригт олгосугай.
3. Зээлийн зарцуулалтад хяналт тавьж, зээлийг зээлийн гэрээний хуваарийн дагуу төлж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.
4. Сонирхлын зөрчилгүй буюу хараат бус гишүүд шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ч.ЧИНЗОРИГ



# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 6 сарын 19 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ НӨХЦӨЛИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн “Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл”-д өөрчлөлт орсныг Хавсралт №1-р шинэчлэн баталсугай.
2. Дээрх журам, нөхцөлийг 2026 оны 6-р сарын 19-ний өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг, “Цамба” салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, “22 Авто цогцолбор” салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



*Ч.Чинзориг* Ч.ЧИНЗОРИГ